



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2014 оны 06 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$5,117.8 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 5,117.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 0.5%-иар буюу 23.4 сая ам.доллараар өссөн. Үүнд экспорт 457.1 сая ам.доллараар өсч импорт 433.7 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 61% буюу 3,114.3 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 15% буюу 785.1 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 22.1%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 4.6%-иар тус тус өсчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -\$156.1 сая

Мөнгөн дүн 2014 оны эхний 6 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл -156.1 сая ам.долларт хүрч, тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 85.1%-иар буюу 890.9 сая ам.доллараар буурчээ. Энэ нь экспорт 22.6%-иар өссөн, импорт 14.1%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан бол 2014 оны эхнээс өсөх хандлага руу орсон. Энэ нь оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсантай холбоотой байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: -\$11.4 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшинд нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлт 2014 оны эхний 3 сард +37.8 сая ам.долларт хүрч 2010 оноос хойш анх удаа 2 сар дараалан эерэг тэнцэлтэй гарсан бол 4,5 сард валютын төлбөртэй импорт өссөнөөр тэнцлийн алдагдал нэмэгдсэн. Гэвч 2014 оны 6 сард валютын төлбөртэй экспорт өсч, импорт буурснаар тэнцэл дахин эерэг дүнтэй гарч, улмаар эхний 6 сарын байдлаар валютын төлбөртэй худалдааны тэнцэл -\$11.4 сая ам.долларт хүрлээ.

Гадаад худалдааны нөхцөл: 1.715 (Туршилт тооцоо)

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.715-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.6%-иар өслөө.


Экспортын үнийн индекс өмнөх жилийн мөн үеэс 8.7%-иар буурсан хэдий ч импортын үнийн индекс 17.5%-иар буурсан нь гадаад худалдааны нөхцөлийн индекс ийнхүү өсөхөд нөлөөлжээ.

Нүүрс болон төмрийн хүдрийн хилийн үнийн бууралтаас шалтгаалан экспортын барааны үнийн индекс буурсан бол импортын үнийн индекс өнгөрсөн оны мөн үеэс буурахад удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмжийн хилийн үнэ буурсан нь тус тус голлон нөлөөлжээ.


Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 6 сар			Өөрчлөлт			
	2014	2013	2012	2014/2013		2013/2012	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	5,117.8	5,094.5	5,566.4	23.4	0.5%	(472.0)	-8.5%
Экспорт	2,480.8	2,023.7	2,253.2	457.1	22.6%	(229.4)	-10.2%
Импорт	2,637.0	3,070.7	3,313.3	(433.7)	-14.1%	(242.5)	-7.3%
Тэнцэл	(156.1)	(1,047.0)	(1,060.1)	890.9	-85.1%	13.1	-1.2%


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Бүтэц: 86%+ 14%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч нийт экспортын 86%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 92%, нийт экспортын 79%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 6.4 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 5.0 нэгж хувиар тус тус өссөн байна.

Өсөлт: +22.6%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 22.6%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 18.8%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн экспортын өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 32%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрс, төмрийн хүдэр болон цайрын баяжмалын экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 17%, 41%, 36%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 15%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 550.2 сая ам.доллараар өссөн бол үнийн бууралтаас шалтгаалж 93.1 сая ам.доллараар буурснаар нийтдээ 457.1 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 530 сая ам.доллараар өсөх нөлөө үзүүлсэн бол төмрийн хүдэр, цайр, мөнгөжөөгүй алтны экспортын тоо хэмжээ буурснаас, мөн чулуун нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 448 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүн болон бусад экспортын бүтээгдэхүүний хувьд үнийн дүн болон тоо хэмжээ зэрэг өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 43.3 болон 33 сая ам.доллараар экспорт өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2014 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар унц тутамд 1,327.3-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 7.5%-иар, өмнөх сараас 6.2%-иар тус тус өссөн байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн (CFR Tianjin) үнэ 2014 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 7,041.0, 93.8 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 6.2%-иар, төмрийн хүдэр 2.2%-иар тус тус өссөн бол, өмнөх жилийн мөн үеэс зэс 7.5%-иар өсч, төмрийн хүдэр 19.5%-иар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2014			2013			Өөрчлөлт		
	Тоо/хэм (МЯН.ТН.КГ)	Дүн	%	Тоо/хэм (МЯН.ТН.КГ)	Дүн	%	Дүн	%	% 2
1. Ашигт малтмал	2,144	86%		1,763	87%		381	↑ 22%	18.8%
Чулуун нүүрс	9,348	448	18%	7,484	542	27%	(95)	↓ -17%	-5%
Зэсийн баяжмал	583	986	40%	283	404	20%	582	↑ 144%	33%
Төмрийн хүдэр/баяж.	2,598	208	8%	3,197	351	17%	(143)	↓ -41%	-8%
Боловсруулаагүй нефть	3,83	320	13%	2,138	202	10%	118	↑ 58%	7%
Цайрын хүдэр ба баяж.	45	48	2%	78	75	4%	(27)	↓ -36%	-2%
Мөнгөжөөгүй алт	2,171	90	4%	3,210	135	7%	(46)	↓ -34%	-3%
Жонш, лейцит, нефелинг	188	30	1%	142	36	2%	(5)	↓ -15%	0%
Молибдений хүдэр/баяж	2	13	1%	2	16	1%	(3)	↓ -19%	0%
2. Ноос, ноолуур	202.7	8%		159.3	8%		43	↑ 27%	2%
Ямааны угаан ноолуур	3,264	132	7%	3,054	112	7%	40.6	↑ 29%	25%
Ямааны самноолуур	203	20	1%	185	18	1%	2.8	↑ 16%	2%
3. Бусад	134	5%		102	5%		33	↑ 32%	2%
Нийт дүн	2,481			2,024			457.1	↑ 22.6%	

%2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	520		(139)		381	
Чулуун нүүрс	135	-143%	(230)	243%	(95)	-17%
Зэсийн баяжмал	430	74%	152	26%	582	144%
Төмрийн хүдэр ба баяжмал	(66)	46%	(77)	54%	(143)	-4%
Боловсруулаагүй нефть	100	85%	18	15%	118	58%
Цайрын хүдэр ба баяжмал	(31)	116%	4	-16%	(27)	-36%
Мөнгөжөөгүй алт	(44)	96%	(2)	4%	(46)	-34%
Жонш, лейцит, нефелинг	(1)	17%	(4)	83%	(5)	-15%
Молибдений хүдэр ба баяжмал	(3)	91%	(0)	9%	(3)	-19%
2. Ноос, ноолуур	115		319		43.3	
Ямааны угаан ноолуур	9.8	24%	30.8	76%	40.6	29%
Ямааны самнасан ноолуур	1.7	62%	1.1	38%	2.8	16%
3. Бусад	18	56%	14	44%	33	32%
Нийт	550.2		(93.1)		457.1	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



Бүтэц: 26% + 41% +20%

Эхний 6 сарын байдлаар нийт импортын 26%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 41%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 20%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 3%-иар өссөн бол хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний хувийн жин 7%-иар буурч, нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хадгалагдсан байна.

Өсөлт: -14.1%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 12%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт 4%-ийг тус тус тайлбарлаж байна. Эхний 3 сарын байдлаар нефтийн импорт нийт импортын бууралтын 8%-ийг тайлбарлаж байсан бол 2 дугаар улиралд нефтийн импорт өссөнөөр уг үзүүлэлт 4% болж буурсан байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 26%-иар буюу 384 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 17%-иар буюу 112 сая ам.доллараар буурсан нь нийт импортыг 14.1%-иар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 3%-иар буюу 23 сая ам.доллараар буурахад удаан эдэлгээтэй барааны импорт, ялангуяа суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 18%-иар буурсан нь голлон нөлөөлжээ. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 5%-д хүрч буурсан байна /Дүрслэл 7/. Түргэн эдэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны эхнээс эхлэн тогтмол түвшинд байгаа бол удаан эдэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны 8 сараас эхлэн тогтмол буурах хандлагатай болсон.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 41%-иар буюу 428 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин барилгын материалын импорт өнгөрсөн оны мөн үеэс 18%-иар буюу 55 сая ам.доллараар өсчээ.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 32%-иар буюу 76 сая ам.доллараар өссөн нь ерөнхий ангиллуудын хувьд өсөлттэй гарсан ганц бүлэг болж байна. Энэ нь цахилгаан эрчим хүчний импортын өсөлтөөр голлон тодорхойлогдож байна. Оюутолгойн зэс, алтны уурхайн үйл ажиллагаа жигдэрснээр 2013 оны 5 сараас эхлэн эрчим хүчний импорт огцом нэмэгдсэн.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 17%-иар буюу 112 сая ам.доллараар буурчээ. Дүрслэл 6-с үзэхэд хилийн үнэ 2012 оны сүүлээс эхлэн буурч, 2013 оны 9 сараас өсөх хандлагатай байсан хэдий ч оны төгсгөлөөс эхлэн буцаад буурч байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2014		2013		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2*
Хэрэглээний бүтээгдэхүүн	691	26%	714	23%	(23)	-3%	-1%
Түргэн эдэлгээтэй	362	14%	349	11%	13	4%	2%
Хүнс	251	10%	250	8%	1	0%	0%
Эм, тариа	39	1%	36	1%	3	9%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	73	3%	64	2%	9	14%	1%
Удаан эдэлгээтэй	329	12%	365	12%	(36)	-10%	-5%
Гутал, хувцас, цунх	27	1%	24	1%	4	15%	1%
Гэр ахуйн цах хэрэгсэл ба тавилга	64	2%	68	2%	(4)	-6%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	199	8%	242	8%	(44)	-18%	-6%
Бусад удаан эдэлгээтэй бараа	39	1%	31	1%	8	26%	1%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1082	41%	1466	48%	(384)	-26%	-12%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	609	23%	1037	34%	(428)	-41%	-29%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	176	7%	429	14%	(254)	-59%	-17%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	433	16%	608	20%	(175)	-29%	-12%
Барилгын материал	365	14%	310	10%	55	18%	4%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	108	4%	119	4%	(11)	-9%	-1%
Аж үйлдвэрлэлийн орц	316	12%	240	8%	76	32%	2%
Хүнсний орц	20	1%	8	0%	12	142%	5%
Химийн бүтээгдэхүүн	47	2%	45	1%	2	5%	1%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	7	0%	8	0%	(0)	-5%	0%
Цахилгаан эрчим хүч	80	3%	34	1%	46	136%	19%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0%	0	0%	0	6%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	162	6%	146	5%	16	11%	7%
Нефтийн бүтээгдэхүүн	538	20%	650	21%	(112)	-17%	-4%
Дизель тунш	301	11%	375	12%	(74)	-20%	-11%
АИ-92, АИ-95	154	6%	154	5%	(1)	0%	0%
А-80 болон бусад	84	3%	121	4%	(37)	-31%	-6%
Бусад	10	0%	1	0%	9	731%	0%
Нийт дүн	2,637		3,071		(434)	-14%	

*2 - Ерөнхий бүлгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

